



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/15

Бүрд сум

**Хоршоо хөгжүүлэх сангийн
зээл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03- дугаар сарын 4-ны өдрийн 153 дугаар тогтоол, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.2, 3.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох зорилгоор иргэдэд хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл 50,000,000 (тавин сая) төгрөгийг олгосугай.

2.Зээл олгох иргэдийн нэрс болон мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3.Иргэдтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын байрны мэдээ тайланг аймгийн ХХААЖДҮГ азарт хүргүүлж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Солонго)-д даалгасугай.

4.Дээрх зээлийг зээлдэгч бүрийн нэрийн дансанд шилжүүлж, хоршоо хөгжүүлэх сангийн орлог, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний сарын 05-ны дотор Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж ажиллахыг Санхүү албаны дарга(Г.Анхтөр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  М.МӨНХБАЯР



622401247
D:My doc,ZD (zahiramj)

Сумын засаг даргын 2024
11-дугаар сарын 10-дний
захирамжийн хавс...



ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН
ХОРШООНЫ ЖАГСААЛТ

№	Зээлд хамрагдсан хоршоо	Зээлийн хэмжээ	Зориулалт	Санхүүжилт олгох хугацаа
1	Бурхант хайрханы хишиг	50,000,000	Мод үржүүлэг бойжуулалтын талбай байгуулах төсөл	11 сар